

Батлав. Монгол хэл бичгийн улсын  
олимпиад зохион байгуулах дэд хорооны  
дарга, доктор *Соронзон* Д. Соронзон



## МОНГОЛ ХЭЛ БИЧГИЙН УЛСЫН ОЛИМПИАДЫН II ДАВААНЫ

### ХII АНГИЙН СУРАГЧДЫН СЭДЭВ

Оноо 40, хугацаа 120 минут

#### Санамж:

1. Даалгавруудыг эх сэдэв дээр биш, тусгай цаасан дээр гүйцэтгэнэ.
2. Ажил тус бүрийн дугаар, дэд дугаарыг тодорхой бичнэ.
3. Зарим даалгаврыг эх сэдвээс нь хуулж бичээд гүйцэтгээрэй. (Тухайлбал өгүүлбэр задлах даалгавар гэх мэт)

Ц.Чимэддорж

#### АРГАЛЬ

*Эвэр угалз аргалын сүрэг рүү  
Эх үр хагацаан онилоход  
Ис тортогтой бууны чинь овоо харааг  
Ижийн сүү халхалж байдаг.  
Бид түүнийг хардаггүй..." (өөрийн шүлгээс)*

Аргалын эвэр шиг мушгирсан улаан уулс... гэж ирээд л шүлэг дотор минь архайж дархайж байх. Тэгтэл бас, аль нэгэн туурганы зураг дээр тэнгэрт угалзран зогсох хэрнээ ойртоод үзье гэвэл ганцхан огло үсрээд цахилан арилахын даваан дээр мэт. Хараад л зогсоод баймаар. Хажууд нь дуулмаар... Асга нураг шаргиулан хэц дунх бараадан бэлчиж яваа олон дотор аргил бууралхан хяруут, за тэгээд шаазгай алаг, буурал сэрвээт зонхилон байх нь тууль мэт ээ.

Усыг нь уухаасаа хайргыг нь залгилах мэт ангаа цангаагаа гаргаад ийш тийш сэртэлзэж зогсоо нь, уулнаас ууланд цуурай хадаан тар нярхийтэл мөргөлдөж байгаа нь, сүүдрээсээ хүртэл зай алдан зогсоо нь... эй чухам л амьд хээ.

Бүргэдийн сүүдэр урж, чонын мөр дээр гишгэлж, зээр гөрөөстэй хамт хүйтэн булаг тагшин, ташлан залгилах хувь дутах эсэхийн завагт яваа бүлтгэр амьтан билээ. Аргаль угалз гэмээнэ одон дээр мөргөлдөж, халтар хархан асгатай шаргилж, мөнх цасны ус шимж, тэнгэрийн цагаан өвс таслан явах учиртай амьтан бүлгээ. Салаа туурт нь хавчуулсан өвс ногоо хүртэл аргалаас өөрөөс нь ургасан мэт. Тийм дагшин гөрөөс бүлгээ.

Хүнд гэмгүй амьтан олоод ир гэвэл Алтайн бүх аргалыг туугаад ирмээр. Гэтэл хүмүүн бидэн нь энэ гэм зэмгүй амьтныг нудархдаа нударч, шаналгаж, шархдуулж, тэвдүүлж, тийчлүүлж байдаг. Говийн чоно гэж голд ормоор хүйтэн амьтан байх. Тэгтэл хүн гэдэг түүнээс хавьгүй долоон дор "чоно" байх. Хоёр чонын дунд аргаль угалз гэдэг алтан эвэрт амьтан амь дүйж явах. Цаана нь гарч бодъё. Цаана нь гарч харъя. Улаан бус, уулсаа дуурайсан бор халтар зүстэй АРГАЛЬ УГАЛЗ гэдэг амьд халуун амьтан биднийг "УЛААН НОМ"-ын дотроос харж байна. Аргаль хүмүүн бидний дунд нэгэн хар ангал. Нэг л харайвал...

### **Нэгдүгээр ажил. Эх, өгүүлбэрийн задлал (20 оноо)**

- 1.1. Энэ эхийн үүдэл (төрсөн) санааг та баримжаалан тодорхойлж бичнэ үү. Энэ тулгуурлах баримт байна уу? (3 оноо)
- 1.2. Эхийн сэдэв, гол санааг тодорхойлж бичнэ үү. (3 оноо)
- 1.3. Дээрх эхээс адилтгал, зүйрлэл, амьдчилал, хэтрүүлэг тус бүрийн жишээ нэг нэгийг бичнэ үү. (4 оноо)
- 1.4. Бүргэд, чоно, зээр зэрэг нь аргальтай тус бүр ямар хандлага харьцаатай амьтан бэ? Түүнийг эхэд хэрхэн дүрсэлсэн бэ? (2 оноо)
- 1.5. Эхийн зорьсон санаа буюу зохиолчийн товч хандлага, үнэлэмж, өнгө аясыг товч тодорхойлно уу. (2 оноо)
- 1.6. Эхийн найруулгын хэв маягийг тодорхойлно уу. (2 оноо)
- 1.7. Дараах өгүүлбэрийг өгүүлбэрийн гишүүдээр зурж, бүтцийг нь тодорхойлон бичээрэй. (4 оноо)

*Аргаль угалз гэмээнэ одон дээр мөргөлдөж, халтар хархан асгатай шаргилж, мөнх цасны ус шимж, тэнгэрийн цагаан өөс таслан явах учиртай амьтан бүлгээ.*

### **Хоёрдугаар ажил. Үг, бүтээврийн задлал (6 оноо)**

- 2.1. Дээрх эхэд орсон дараах үгсийн утгыг тайлбарла. (2 оноо)  
*хэц дунх, зайн алдан, Улаан ном, дагшин, угалз, хувь дутах*
- 2.2. Дээрх (1.7-д байгаа) өгүүлбэрт орсон харьяалахын тийн ялгалтай үгсийг бичнэ үү. (2 оноо)
- 2.3. Эхэд орсон “нудрахдаа” гэдэг үгийг бүтээврээр задалж, бүтээвэр (язгуур, дагавар, нөхцөл) тус бүрийг нэрлэ. (2 оноо)

### **Гуравдугаар ажил. Зохион бичих чадвар (4 оноо)**

Дээрх эхийг уншаад төрсөн сэтгэгдлээ 70-80 үгэнд багтаан бичнэ үү. (4 оноо)

### **Дөрөвдүгээр ажил. Монгол бичиг (10 оноо)**

Дээрх эхийн “Бүргэдийн сүүдэр урж, ... дагшин гөрөөс бүлгээ.” хэсгийг монгол бичигт хөрвүүлэн бичнэ үү.